# Татварын талаарх илэн далангүй яриа

# “Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар”

## ААНБОАТ-ын талаарх бодит байдал

Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар (ААНБОАТ) нь бизнесийн үйл ажиллагаанаас орсон орлогод ногдох албан татвар юм. ААНБОАТ нь зөвхөн аж ахуйн нэгж, байгууллагаар хязгаарлагдахгүй. Төрийн бус байгууллага болон түүнтэй ижил төстэй бусад байгууллагууд үүнд мөн хамаарна.

ААНБОАТ-ын одоо мөрдөж буй хувь хэмжээ нь 15, 30 хувь гэсэн хоёр шатлалтай байна. Аж ахуйн нэгж, байгууллагын 100 сая төгрөг хүртэлх орлогод 15 хувиар тооцон татвар ногдуулна. 100 сая төгрөгөөс дээш орлогод эхний 100 сая төгрөгт 15 хувиар, 100 сая төгрөгөөс дээш орлогод 30 хувиар тооцон татвар ногдуулан төлнө. ”Орлого” гэдгийг татварын зорилгоор татвар ногдуулах орлого гэж ойлгоно.

## Ямар хэмжээний орлого ордог вэ?

**ААНБОАТ-ын хувь, хэмжээ, жилийн орлого (сая төгрөг):**

| Хувь | Улсын орлого | | Улсын нийт орлогод эзлэх хувь | |
|---|---|---|---|---|
| | 2003 | 2004 | 2003 | 2004 |
| 15% | 4,330 | 5,859 | <1% | <1% |
| 30% | 64,451 | 94,045 | 12% | 14% |




## ААНБОАТ-ыг хэн төлдөг вэ?




ААНБОАТ-ыг голчлон томоохон аж ахуйн нэгж, байгууллагууд төлдөг. ААНБОАТ-ын нийт дүнгийн 67 хувь буюу 60 тэрбум төгрөгийг төрийн өмчит уул уурхайн компани, 22 хувийг Монголын томоохон 100 аж ахуйн нэгжүүд, 7 хувийг төрийн өмчит бусад компаниуд төлж байгаа бол зөвхөн 4 хувийг жижиг, дунд аж ахуйн нэгжүүд төлж байна.

<table>
<tr>
<td>Татвар ногдуулах орлого гэж юу вэ?</td>
<td>
Аж ахуйн нэгж, байгууллагуудын хувьд татвар ногдуулах орлого гэдэг нь нийт орлогоос үйл ажиллагааны зардлыг хасаж үлдсэн хэсэг юм.
<ul>
<li>Жилийн турш хийсэн бүхий л борлуулалтыг нийт орлого гэж ерөнхийлөн ойлгоно.</li>
<li>Борлуулалттай холбогдон гарч буй зардлыг үйл ажиллагааны зардал гэнэ. Үүнд борлуулсан бүтээгдэхүүний өртөг (түүхий эд, хангамжийн материал, шууд хөдөлмөрийн зардал г.м.), удирдлагын зардал, орлого олоход зайлшгүй гарах бусад зардал орно.</li>
<li>Татвар ногдуулах орлогыг тооцоход зарим хасагдах зардлын хэмжээг хязгаарладаг. Жишээ нь, зар сурталчилгаа, ажиллагсдын сургалт, давтан сургалтын зардлын нийлбэр нь татвар ногдуулах орлогын 10 хувиас хэтэрч болохгүй.</li>
<li>Зарим зардлыг тохиромжгүй, эсхүл муу удирдлагын үр дагавар гэж үзэн хасагдах зардалд оруулдаггүй. Үүнд найдваргүй авлагын зардал, бараа, материалын хэвийн хорогдол, албан татвар төлөгчийн буруугаас бусдад учруулсан хохирлыг нөхсөн төлөөс, сайн дурын даатгалын хураамж зэрэг орно.</li>
</ul>
</td>
</tr>
<tr>
<td>ААНБОАТ-ыг тооцох загвар</td>
<td>
Та өөрийн ААНБОАТ-ыг тооцно уу:
<table>
<tr><th></th><th></th><th>Жишээ</th><th>Танай аж ахуйн нэгж</th></tr>
<tr><td>Нийт орлого</td><td></td><td>800,000,000</td><td></td></tr>
<tr><td>Хасагдах зардал:<ul><li>Борлуулсан бүтээгдэхүүний өртөг</li><li>Удирдлагын зардал</li><li>Бусад зардал</li></ul>Нийт хасагдах зардал</td><td>340,000,000<br>80,000,000<br>120,000,000</td><td>540,000,000</td><td></td></tr>
<tr><td>Татвар ногдуулах орлого (Орлогоос зардлыг хасна)</td><td></td><td>260,000,000</td><td></td></tr>
<tr><td>Орлогын албан татварын тооцоо:</td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Эхний 100,000,000 төгрөгийн орлогод 15%</td><td>15,000,000</td><td></td><td></td></tr>
<tr><td>100,000,0000 төгрөгөөс дээш татвар ногдуулах орлогод 30%</td><td>48,000,000</td><td></td><td></td></tr>
<tr><td>Татварын нийт дүн</td><td></td><td>63,000,000</td><td></td></tr>
</table>
</td>
</tr>
</table>

---

Энэхүү мэдээлэл нь татварын шинэчлэлийн талаар нийт ард иргэдийн санаа бодлыг сонсох зорилгоор Сангийн Яам, Үндэсний Татварын Ерөнхий Газраас явуулах “Татварын талаарх илэн далангүй яриа” сэдэвт цуврал хэлэлцүүлгийн гурав дугаар юм. Та бүхэн Татварын шинэчлэлийн хуулийн төслийн англи, монгол хувилбарыг “Нээлттэй засаг” вэб сайт (www.open-government.mn), Сангийн Яамны вэб сайт (www.mof.pmis.gov.mn), ҮТЕГ-ын вэб сайт (www.mta.mn)-аас үзэж, саналаа ирүүлж болно.